

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН

2022.09.05-2022.09.09

Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Үйл ажиллагааны гүйцэтгэл
Барилга хот байгуулалтын хэлтэс		
1	Барилга угсралтын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Улсын бүртгэлээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Дархан сум, 13-р багт “Альфа констракшн” ХХК-ний захиалгаар баригдсан үйлчилгээтэй орон сууцны барилга нь 2014 оны 11-р сарын 12-ны өдрийн 2014/26-II дугаартай барилга ашиглалтад оруулах комиссын актаар баталгаажсан тухай тодорхойлолтыг албан бичгээр хүргүүлсэн. ✓ Мөнх нарны сүлд ХХК-ний эзэмшил газар дээрээ архитектур төлөвлөлтийн даалгавар хүссэний дагуу олгох боломжгүй тухай албан хүсэлтийг өгсөн. Учир нь Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12-р сарын 04-ний өдрийн 2/07 дугаар тогтоолоор Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг баталсан байдаг нь тухайн байгууллагын олгогдсон газартай давхцсан. ✓ Дархан-Уул аймаг, Дархан сум, 14-р багт байрлалтай “Бэгч булган” ХХК-ний зөрчилтэй үйлчилгээний барилга газраасаа илүү гарган өргөтгөл хийж байсныг зогсоож мэдэгдэх хуудасыг өгсөн. ✓ Засгийн газрын 213-р тогтоолын дагуу барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2 барилгад олгосон. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Дархан сумын 11-р багт “Их Идрүүн” ХХК-ний үйлчилгээний 19,3м * 18,5м хэмжээтэй зорьтой 9-н давхар үйлчилгээний барилга - Дархан сумын 14-р багт 7-р цэцэрлэгийн өргөтгөлийн 45м*21м хэмжээтэй 100 хүүхдийн 2 давхар цэцэрлэгийн барилга
2	Барилгын материал үйлдвэрлэл	<p>Хонгор сум 1-р баг Шийрийн бригад орчимд ажиллаж байгаа шохой, дайрга үйлдвэрлэж буй ААНБ-уудын бүтээгдэхүүнийг үзэж шалгалаа. Үүнд</p> <ul style="list-style-type: none"> ✓ Түмэн зул энерги ХХК худалдан авсан /Ворлддэйнт ХХК-2020 онд 7 га газар/. Гэхдээ газраа нэр шилжүүлж аваагүй байна. Шүүхийн маргаантай. 2022 онд бүтээгдэхүүн үйлдвэрлээгүй, технологийн зааврыг батлуулахаар БМҮХолбоонд хүргүүлсэн. ✓ Дархан Эрдэс Шохойт Шийр ХХК- Ворлддэйнт ХХК-аас 3 га газар худалдан авсан ба газрын гэрчилгээ удахгүй гарна. Мөн БМҮХолбоонд хүсэлтээ өгсөн. ✓ Иннова ложистик ХХК-тусгай зөвшөөрөлтэй ✓ Мөнхболор Эрдэнэ ХХК ✓ Силикат ХК ✓ Идэрхайрхан ХХК ✓ Тулгат шийр ХХК ✓ Сутайн үхэр чулуут ХХК <p>МҮ-1.3 Цемент, шохой, магни, гөлтгөнө болон холимог барьцалдуулагч материалын үйлдвэр (Шатаасан шохойн үйлдвэрлэл) чиглэлээр үйлдвэрлэл эрхэлж байна. ААНБ нь өөрсдөө түүхий эдээ олборлож, бутлан ангилж, шатаасан шохойг гарган ажиллаж байна.</p> <p>Цаашид үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлөө шинээр болон дууссан хугацааг сунгуулж аймгийн мэдээллийн санд бүртгүүлж ажиллах, шинжилгээний бичигтэй бүтээгдэхүүнийг нийлүүлэх шаардлагатай байгааг тайлбарлан 2022.08.30 №532 албан тоотыг хүргүүлж ажилласан.</p>
Газрын удирдлагын хэлтэс		

3	Суурь судалгаа, газрын мониторинг	<ol style="list-style-type: none"> 1. 12 иргэний газар эзэмших эрх шилжүүлэх, зориулалт өөрчлөх, талбайн хэмжээ өөрчлөх хүсэлтийг хүлээн авч ГЭЗХХШийдвэрлэх хурлын материал бэлдсэн. 2. 26 захиалгат хянан баталгааны тайланг хянаж баталгаажуулсан. 3 тайланг хянаж буцаасан. 3. Захирамж гарсан 17 иргэний газар эзэмших гэрээ гэрчилгээг үүсгэж, утсаар мэдэгдсэн. 4. 4505700053, 4505701847 дээрх хоёр нэгт талбарт 2001 оноос хойших нөхөн бүрдүүдэлт хийв. 2020, 2021 оны АОС зориулалттай хувийн хэрэгт оруулаагүй шийдээгүй материал болон өргөдлийг ялгаж авсан. Архивт жагсаалт үүсгэн хүлээлгэж өгсөн.
4	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөлийн чиглэл	<ul style="list-style-type: none"> ✓ Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Прокурорын газарт шалгагдаж байгаа иргэн, ААНБ -ын нийт 2 албан бичгийн лавлагааг газрын кадастрын системээс аймгийн хэмжээнд шүүж хариуг хүргүүлсэн. ✓ Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дэргэдэх газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх хурлаар хэлэлцүүлсэн иргэн, хуулийн этгээдийн хариуг албан тоотоор хүргүүлсэн /2022-09-06 -ны өдрийн Засаг даргын захирамжийн биелэлтийг хангаж ажилласан нийт 12 иргэн, хуулийн этгээд/
5	Газрын кадастрын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагуудын хийсэн хэмжилтүүдийг хянасан. Үүнд ✓ 6 Иргэний материалыг хүлээн авч 4 иргэний байшинг кадастрын мэдээллийн санд оруулж кадастрын зургийг гаргаж өгсөн. 2 иргэний нэгж талбарыг кадастрын мэдээллийн санд хувааж, өөрчилсөн. ✓ Өмчлөлийн газраа худалдах, өвлүүлэх, бэлэглэх гэрээгээр шилжүүлж байгаа нийт 10 иргэний цахим хүсэлтийг мэдээллийн санд өөрчлөлт хийж, кадастрын зургийг гаргаж өгсөн. ✓ Дархан сумын Засаг даргын орлогч П.Ихбаяраар ахлуулсан ажлын хэсэгт орж Гэр хорооллын бүсээс мал, туслах аж ахуйг гаргах, зөвшөөрөлгүй буусан, газар чөлөөлөх шаардах хуудас хүргүүлсэн айлууддаа хяналт тавьж явсан. ✓ Шинэчилсэн бүртгэлд орох шаардлагатай 58 нэгж талбарын нөхөн бүрдүүлэлтийг хийсэн.
Захиргаа аж ахуйн чиглэл		
1	Захиргаа, хүнийн нөөц, хууль эрх зүй	<p>Шүүх хуралдаан:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Улаанбаатар менежмент ХХК-ний нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох Захиргааны хэрэгт нэхэмжлэгч талын гомдолтой Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдаан 2022/09/07-ны өдрийн хуралдаанд шүүхээс гомдлын шаардлагыг хэрэгсэхгүй болгож, Захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн 2022/06/28-ны өдрийн 08 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн. ✓ Батбармат ХХК-ний нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэргийн урьдчилсан хэлэлцүүлгээр 2022/09/16-ны өдөр товлогдсон. ✓ Жоконди ХХК-ний нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэргийн урьдчилсан хэлэлцүүлгээр 2022/09/21-ний өдөр Шүүх хурал товлогдсон. ✓ Айтүүлс ХК-ний нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэргийн урьдчилсан хэлэлцүүлгээр 2022/09/19-ны өдөр Шүүх хурал товлогдсон. ✓ Миракклад ХХК, иргэн Ч.Чинбаатар нарын нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаан 2022/09/05-ны өдөр хуралдаж Нэхэмжлэгч нарын шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. <p>Захирамжийн төсөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Дархан-ИЗОУИС-ийн газар эзэмших эрхийг хүчингүй болгуулхаар аймгийн Засаг даргын захирамжийн төслийг холбогдох хэлтсийн дарга нараар хяналтын хуудсыг тойруулж, танилцууллаа.
2	Мэдээллийн технологи, нярав	<p>Мэдээлэл:</p> <p>70376471 нээлттэй утсаар 0 иргэн /Нүүж өөр өрөөнд орсон тул утасны үзүүр орж ирээгүй тул/, байгууллагын Facebook хуудсанд ирсэн 6 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв.</p> <p>2022-09-08-ны өдөр цахим төвд ажиллаж, иргэдэд газрын цахим системд хэрхэн нэвтэрч, хүсэлт илгээх талаар заавар зөвлөгөө өгч ажиллав.</p>

		<p>Архивт байгаа Дархан сумын Өргөө, 4, 5, 7-р багуудын гаражийн зориулалттай газрын нэгж талбарын хувийн хэргүүдийг цэгцэлж янзлахад туслав.</p> <p>Мэдээллийн технологи:</p> <p>Байгууллагын цахим хуудсан дээр мэргэжилтнүүдийн танилцуулгын QR кодоор нэвтрэх холбоосыг үүсгэж байрлуулав. Мэргэжилтнүүдийн хаягийн эх дээр QR код нэмж дахин өөрчлөв.</p> <p>Шарын гол сумын газрын даамлын компьютерийн гэмтлийг засварлуулав. Мэргэжилтнүүдэд дундын мэдээллийн сангийн файлуудаа цэгцэлж, хуулж авахыг анхааруулав.</p> <p>Нярав:</p> <p>20 ширхэг Нэгж талбарын хувийн хэрэг нугалж мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 16 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 39 ширхэгийг хүлээж авч бүртгэв.</p> <p>Шаардах хуудсаар 3 төрлийн 4 ширхэг бараа материал олгов.</p>
--	--	--

Тайлан боловсруулсан:
Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Хянасан:
Газрын удирдлагын хэлтсийн дарга

Б.Золбаясах
Г.Нямдорж